

“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН  
АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ  
БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ” УТУГ-ЫН  
ЗАХИРАЛ

У.БААТАР

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОД ИХ БАГТААМЖИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЭЛ “МЕТРО”-Г БАРИХ ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ  
ХЭЛЭЛЦЭЭР, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.05.10

№ ЗҮД2024/002

Улаанбаатар хот

**Нэг. Үндэслэл**

- 1.1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 411 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/387 дугаар захирамж.

**Хоёр. Зорилго**

- 2.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахад хэлэлцээрийн үе шатанд оролцох;
- 2.2. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад шалгарсан компанитай гэрээ байгуулахад хэлэлцээрээр харилцан тохиролцсон нөхцөлийг гэрээнд тусгах, гэрээний төслийг эцэслэн бэлтгэх;
- 2.3. Энэхүү ажлын даалгаврын 2.1, 2.2-т заасан зорилгыг хэрэгжүүлэхэд дотоод болон шаардлагатай тохиолдолд гадаадын олон улсын туршлагатай мэргэжлийн баг ажиллуулж зөвлөмж, дүгнэлт, тайлан гаргуулах.

**Гурав. Хүрэх үр дүн**

- 3.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх олон улсын тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахад хэлэлцээрт оролцох, гэрээний төсөл, хавсралтыг эцэслэн бэлтгэх, хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг хийж гүйцэтгэх.

**Дөрөв. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ**

Зөвлөх үйлчилгээний баг нь Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээнд хууль зүйн болон бусад чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг дараах хүрээнд хийж гүйцэтгэнэ:

1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх олон улсын тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахад хэлэлцээрийг зохион байгуулах;
2. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх олон улсын тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчтой байгуулах гэрээний нөхцөлийг эцэслэн тодорхойлох, хавсралтуудыг бэлтгэх;

#### **4.1. Хэлэлцээрийг зохион байгуулах:**

- 4.1.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх олон улсын тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахад хэлэлцээрийг англи, монгол хэл дээр зохион байгуулах;
- 4.1.2. Энэ ажлын даалгаврын 4.1.1-д заасан хэлэлцээрт шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлж, Захиалагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн гэрээний нөхцөлийг санал болгох;
- 4.1.3. Энэ ажлын даалгаврын 4.1.1-д заасан хэлэлцээрт Захиалагчийн эрх ашгийг хамгаалж оролцох;
- 4.1.4. Энэ ажлын даалгаврын 4.1.1-д заасан хэлэлцээрт оролцох үед Захиалагчийг шаардлагатай мэдээ, мэдээлэл, хууль зүйн зөвлөх үйлчилгээгээр хангах;
- 4.1.5. Гэрээний хэлэлцээрийн үед гэрээний нөгөө талтай төслийн зардлын тооцооллыг ажлын цар хүрээтэй уяж, гэрээний гүйцэтгэлийг оновчтой зохион байгуулах;
- 4.1.6. Гэрээний хэлэлцээрийн үед гэрээний нөгөө талтай гэрээний хавсралтуудад шаардагдах мэдээлэл, баримтыг эцэслэн тохирч хавсралтыг эцэслэн боловсруулах.

#### **4.2. Гэрээний нөхцөлийг эцэслэн тодорхойлох, хавсралтуудыг бэлтгэх.**

- 4.2.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх олон улсын тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчтой хэлэлцээрийн үр дүнд бий болсон гэрээний нөхцөлийг эцэслэн тодорхойлж, гэрээ байгуулахад оролцох, зөвлөгөө өгөх;
- 4.2.2. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх олон улсын тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчтой эцэслэн тохирсон гэрээ, хавсралтыг англи, монгол хэл дээр бэлтгэх.

#### **4.3. Олон улсын жишиг гэрээний сургалтыг Захиалагч талын ажилтнуудад зохион байгуулах**

4.3.1. Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос (FIDIC) эрхлэн гаргадаг зөвлөх үйлчилгээний гэрээний сургалтыг Захиалагч талын 20 ажилтанд зохион байгуулах;

4.3.2 Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний талаарх сургалт зохион байгуулах.

#### 4.4.Зөвлөхөөс Захиалагчид ирүүлэх тайлан

4.4.1. Зөвлөх нь хийж гүйцэтгэсэн ажлынхаа дундын болон эцсийн тайланг Захиалагчид ирүүлнэ.

#### Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай хүний нөөц

№	Албан тушаал	Тавигдах шаардлага	Хүний тоо	Хүн/сар
1	Багийн ахлагч	1. Хууль зүйн магистр болон түүнээс дээш зэрэгтэй (ОУ-д суралцаж авсан байх) 2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх 3. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хэрэгжүүлсэн эрчим хүч, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын 3-аас доошгүй төслийн хэлэлцээрт оролцсон, ФИДИК (FIDIC) гэрээний төсөл боловсруулсан байх	1	6 сар
2	Хуульч	1. Хууль зүйн магистр болон түүнээс дээш зэрэгтэй (ОУ-д суралцаж авсан байх) 2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх 3. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хэрэгжүүлсэн эрчим хүч, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслийн хэлэлцээрт оролцсон, ФИДИК (FIDIC) гэрээний төсөл боловсруулсан байх	1	6 сар
3	Хууль зүйн мэргэжилтэн	1. Хууль зүйн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй 2. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх 3. Хөрөнгө оруулалт, IPO, өрийн хэрэгсэл гаргах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх	1	6 сар


#### Танилцсан:

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-ын Захиргаа, хүний нөөцийн албаны дарга

 Т.Батдорж/

#### Боловсруулсан:

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

 М.Уранбилэг/